



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД Д.БАТЛУТ ТАНАА

2026.01.12 № 01

Хүний амьд явах эрхийн
хэрэгжилтийн тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

Сүүлийн жилүүдэд цэргийн алба хааж буй цэргийн албан хаагчдыг дарамтлах, зодох, эрүүл мэндэд хохирол учруулах, улмаар амь насыг нь бүрэлгэхтэй холбоотой хүний эрхийн ноцтой зөрчил бүртгэгдэх болсон нь олон нийтийн санааг зовоосон тулгамдсан асуудал болоод байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрхийн асуудлаарх олон улсын гэрээ, Цэргийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй шууд холбоотой асуудал юм. Иймд батлан хамгаалах салбарт алба хаадаг цэргийн алба хаагчдын талаарх дараах мэдээллийг ирүүлнэ үү.

1.Үндсэн хуульд заасан Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх “амьд явах эрхтэй” гэсэн заалтын хэрэгжилт ямар түвшинд байгаа болон сүүлийн 30 жилийн хугацаанд батлан хамгаалахын салбарт амь насаа алдсан, эрүүл мэндээрээ хүнд, хөнгөн хэлбэрээр хохирсон цэргийн албан хаагчдын тоог он, анги салбар, шалтгаанаар (дарамт, зодох, осол, амиа хорлолт, бусад) ангилан гаргасан нэгдсэн судалгаа, тайлан байдаг эсэх талаар албан ёсны баримтад тулгуурласан мэдээлэл;

2.Дээрх төрлийн хэдэн хэрэг, зөрчилд эрүүгийн болон бусад хариуцлага оногдуулсан талаар болон хэрэг, зөрчлийг хяналт шалгалт, дотоод аудит хийх зэргээр хэрхэн илрүүлдэг талаар, мөн шүүхийн шийдвэр гарсан тохиолдлын тоо, дүн, хохирогч болон түүний ар гэрт олгосон нөхөн олговор, сэтгэл зүйн болон нийгмийн дэмжлэгийн талаар мэдээлэл болон дээр дурдсан хүний эрхийн зөрчлүүдийн үндсэн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлс, урьдчилан сэргийлэх талаар холбогдох байгууллагуудаас авсан арга хэмжээ, түүний үр дүнд дүн шинжилгээ хийсэн эсэх, ойрын болон дунд хугацаанд ямар бодлогын шинэчлэл хийхээр төлөвлөж байгаа талаар;

2026000001

3.Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гомдол, мэдээллийг хүлээж авахтай холбоотой зохицуулалт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, алба хаагчдад зориулсан сэтгэл зүй, хүний эрхийн сургалт, хөтөлбөрүүд, түүний үр дүн, үр нөлөөг үнэлсэн талаарх мэдээлэл, цаашид авах арга хэмжээний зорилтын талаарх мэдээлэл.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



С.ЭРДЭНЭБОЛД

2026000001